



**МИК ХОЛДИНГ ХК БОЛОН
ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон
хараат бус аудиторын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31

МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

МИК ХОЛДИНГ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Мягмарын Мөнхбаатар, Гүйцэтгэх захирал Бадамхатангийн Гантулга, Санхүүгийн удирдлагын газрын захирал Ганбаатарын Сансар бид МИК Холдинг ХК болон түүний охин компаниуд ("Групп")-ын нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудад нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ")-ноос гаргасан журмын дагуу, үнэн зөв, шударгаар тайлагнасан гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Тамга


Мягмарын Мөнхбаатар
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга


МИК ХОЛДИНГ ХК
1116216036-н/5221978
УЛААНБААТАР ХОТ


Бадамхатангийн Гантулга
Гүйцэтгэх захирал


Ганбаатарын Сансар
Санхүүгийн удирдлагын газрын захирал

Улаанбаатар хот

Огноо: 2022 оны 3 дугаар сарын 18



МИК ХОЛДИНГ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
25-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2022.03.18 дугаар 21-УБ/03/48

танай _____-ны дугаар _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид “МИК ХОЛДИНГ” ХК болон түүний охин компаниуд (“Групп”)–ын 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон жилийн нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудад нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)–оос гаргасан журмын дагуу үнэн зөв, бодитой тайлагнасан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)–ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэхүү тайлангийн *Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт харуулсан. Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Группээс хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлээр аудитын гол асуудлууд гэж тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд гол асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа гол асуудалдаа тус бүрчлэн дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудал бүрийг аудитаар хэрхэн авч үзснийг доор харуулсан болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлага болон асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг аудитор биелүүлсэн. Иймд нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэх нь аудитын нэг хэсэг юм. Гол асуудлуудыг авч үзэхдээ гүйцэтгэсэн аудитын горимуудын үр дүн нь нэгтгэсэн санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

**МИК ХОЛДИНГ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Аудиторын гүйцэтгэсэн горим
<p><i>Татварын тооцоолол үнэн зөв байдал, ТЗК-уудын ирээдүйд хуваарилах ногдол ашигтай холбоотой суутган тооцох татвар:</i></p> <p>Группийн татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.</p> <p>Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Групп татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Группт татварын эрсдэл байсаар байна.</p>	<p><i>Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой аудиторын гүйцэтгэсэн горимууд:</i></p> <ul style="list-style-type: none"> - Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох; - Татварын хууль, журам болон практикийн туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Групп ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх; - Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.
<p><i>Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн тооцоолол</i></p> <p>Группийн удирдлага мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, санхүүгийн хөрөнгө оруулалт болон худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагын үнэ цэнийн бууралтуудад ихээхэн хэмжээний хийсвэр тооцоолол ашигладаг.</p> <p>Группийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, санхүүгийн хөрөнгө, худалдан авсан орон сууцны зээлийн авлага нь өндөр дүнтэй бөгөөд холбогдох тооцооллын нөхцөл байдлаас үүдэн эдгээр санхүүгийн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг аудитын гол асуудал гэж үзсэн.</p> <p>Үнэ цэнийн бууралтын сангийн холбогдох Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, СТОУС-ийн дагуу хийгдэх тооцоолол, үнэлэмжийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулсан.</p>	<p><i>Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн талаарх аудиторын гүйцэтгэсэн горим:</i></p> <p>Бид Группийн зээлийн эрсдэлийн удирдлагын талаар, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагын болон санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг тооцоолохдоо Группийн ашигласан загвар, өгөгдөл, үнэлэмжүүдийн талаарх ойлголт авах, Үнэ цэнийн бууралтын сангийн тооцоололд ашиглагдах үндсэн мэдээллийг дотоод эх үүсвэрээс авч, холбогдох мэдээллүүдтэй харьцуулах, Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгууд СТОУС-ын дагуу хийгдэж байгаа эсэхийг үнэлэх.</p>

**МИК ХОЛДИНГ ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

<i>Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагын гэрээний өөрчлөлтөөс үүсэх алдагдлын тооцоолол</i>	<i>Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагын гэрээний өөрчлөлтөөс үүсэх алдагдлын тооцоололд аудиторын гүйцэтгэсэн горим:</i>
<p>2020 оны 11 дүгээр сард сард Коронавируст халдвар /COVID-19/-ын эдийн засаг, ипотекийн зээлийн зах зээлд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газар болон Монголбанк нь орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд олгогдсон ипотекийн зээлийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хойшлуулах шийдвэр гаргасан. Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагад хийгдсэн гэрээний өөрчлөлтийн алдагдлын тооцооллыг аудитын гол асуудал гэж үзсэн.</p> <p>Группийн удирдлага нь худалдан авсан орон сууцны зээлийн гэрээний нөхцөлд орсон өөрчлөлтийн дагуу мөнгөн урсгал болон худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагыг үнэлсэн. Үр ашигт хүүгийн түвшнээр дисткаунтчилах мөнгөн гүйлгээний өөрчлөлтөд үндэслэн Групп нь худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагад хойшлуулсан зээлийн гэрээний өөрчлөлтийн алдагдлыг СТОУС-ын дагуу хүлээн зөвшөөрсөн.</p>	<p>Бид худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагын гэрээний өөрчлөлтөөс үүсэх алдагдлын тооцооллын талаарх Группийн ашигласан загвар, өгөгдөл, үнэлэмжүүдийн талаарх ойлголт авах, Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлагын гэрээний өөрчлөлтөөс үүсэх алдагдлын тооцоололд ашиглагдах мэдээллийг дотоод эх үүсвэрээс авч, холбогдох мэдээллүүдтэй харьцуулах, 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаагаар зээлийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн хүсэлт ирүүлсэн зээлдэгч нарын тоон мэдээлэл, шийдвэрлэсэн байдлын талаарх удирдлагын шийдвэрийг үнэлэх.</p> <p>Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгууд СТОУС-ын дагуу хийгдэж байгаа эсэхийг үнэлэх.</p>

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Группийн захирлууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэг нь аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл багтана.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудад өгсөн аудиторын дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа нэг хэлбэрийн баталгаажуулалтын дүгнэлт гаргаагүй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг хариуцлага нь бусад мэдээллийг уншиж тэдгээр бусад мэдээллүүд нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл материаллаг алдаатай байгаа эсэхийг авч үзэх явдал юм.

Хэрэв аудитын тайлангийн өдрөөс өмнө олж авсан бусад мэдээллүүд дээр хийсэн өөрсдийн ажил дээр үндэслэн энэ бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан байна гэж дүгнэвэл энэ тухай тайлагнах шаардлагатай. Энэ талаар тусгайлан тайлагнах зүйл аудиторт байхгүй болно.

МИК ХОЛДИНГ ХК–ийн хувьцаа эзэмшигчдэд ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-д нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СЗХ-оос гаргасан журмын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Группийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаатай дотоод хяналтын ойлголтыг олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг

**МИК ХОЛДИНГ ХК–ийн хувьцаа эзэмшигчдэд
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

- Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг оролцуулан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлж нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд Группд хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авдаг. Бид мөн группийн аудитын чиглэл, хяналт, үр дүн, гүйцэтгэлд хариуцлага хүлээдэг. Аудитын ажлын дараа бид зөвхөн өөрсдийн гаргасан аудитын дүгнэлтдээ л хариуцлага хүлээсэн хэвээр байна.

Бид бусад асуудлуудын дундаас төлөвлөсөн ажлын хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын алнваа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлэх нь тухайн мэдээллээс олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль” -ийн 94-р зүйлд заасны дагуу Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

С.Мөнхбаяр
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер
Мэжик Консалтинг Аудит ХХК



Улаанбаатар хот, Монгол Улс
2022 оны 3 дугаар сарын 18

МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тодруулга	2021	2020
		мян.төг	мян.төг
Хүүгийн орлого	3	363,864,023	371,396,730
Хүүгийн зардал	4	(275,178,917)	(287,720,558)
Цэвэр хүүгийн орлого		88,685,106	83,676,172
Хураамж, шимтгэлийн зардал	5	(9,614,343)	(9,585,005)
Үйл ажиллагааны бусад орлого	6	3,505,711	11,214,327
Үйл ажиллагааны нийт орлого		82,576,474	85,305,494
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт/(зардал)	7	11,099,582	(17,457,868)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгийн олз/(гарз)	18	4,502,108	(8,431,481)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн олз/(гарз)	19	(15,942,190)	22,758,108
Худалдан авсан орон сууцны зээлийн төлбөр хойшлуулсны алдагдал	8	(196,070,244)	(163,810,050)
Баталгаажсан бондын төлбөр хойшлуулсны орлого	9	14,484,838	-
Үйл ажиллагааны цэвэр орлого/(алдагдал)		(99,349,432)	(81,635,797)
Үйл ажиллагааны зардал	10	(13,101,897)	(12,084,699)
Үйл ажиллагааны бусад зардал	11	(20,284,503)	(33,539,392)
Татварын өмнөх алдагдал		(132,735,832)	(127,259,888)
Орлогын албан татварын хөнгөлөлт/(зардал)	12.1	(13,848,678)	15,305,193
Нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн алдагдал		(146,584,510)	(111,954,695)

МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ОХИН КОМПАНИУД
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба банкн дахь данс	13	549,820,809	224,428,670
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	14	80,766,979	95,649,826
Буцаах нөхцөлтэй орон сууцны зээлийн багцын авлага	15	364,341,576	614,463,700
Бусад буцаах нөхцөлтэй зээлийн авлага	16	44,840,080	-
Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлага	17	2,901,349,797	2,854,533,413
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	18	145,499,187	146,268,450
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хөрөнгө	19	66,638,901	78,274,700
Бусад хөрөнгө	20	30,180,342	2,776,836
Үндсэн хөрөнгө	21	37,709,674	32,353,623
Биет бус хөрөнгө	22	201,833	200,196
Орлогын албан татварын уьдчилж төлсөн төлбөр	12.2	1,566,195	830,239
Хойшлогдсон татварын хөрөнгө	12.3	3,009,508	19,419,016
НИЙТ ХӨРӨНГӨ		4,225,924,881	4,069,198,669
ӨР ТӨЛБӨР			
Бусад өр төлбөр	23	13,194,729	15,136,583
Зээлээр авсан эх үүсвэр	24	41,581,993	41,919,385
Бонд	25	1,004,976,075	825,603,454
Баталгаажсан бонд	26	3,141,395,589	3,007,051,362
Орлогын албан татварын өр	12	25,875	218,008
Хойшлогдсон татварын өр	12.3	20,604,092	28,538,839
НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,221,778,353	3,918,467,631
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Энгийн хувьцаа	27	20,709,320	20,709,320
Хувьцааны урамшуулал	27	52,225,115	52,225,115
Халаасны хувьцаа	27	(62,143,136)	(62,143,136)
Хуримтлагдсан ашиг		(6,644,771)	139,939,739
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		4,146,528	150,731,038
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		4,225,924,881	4,069,198,669

МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ОХИН КОМПАНИУД
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Энгийн Хувьцаа	Хувьцааны урамшуулал	Халаасны хувьцаа	Нөөц хөрөнгө*	Нийт өөрийн хөрөнгө
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2020.01.01-ний өдрийн байдлаар	20,709,320	52,225,115	(62,143,136)	251,894,434	262,685,733
Тайлан үеийн цэвэр алдагдал	-	-	-	(111,954,695)	(111,954,695)
2020.12.31 -ний болон 2021.01.01-ний өдрийн байдлаар	20,709,320	52,225,115	(62,143,136)	139,939,739	150,731,038
Тайлан үеийн цэвэр алдагдал	-	-	-	(146,584,510)	(146,584,510)
2021.12.31-ний өдрийн байдлаар	20,709,320	52,225,115	(62,143,136)	(6,644,771)	4,146,568

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн ТЗК-иудад хязгаарлалттай нөөц хөрөнгө нь 139,402,007 мянган төгрөг (2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 206,814,407 мянган төгрөг) байсан. Уг хязгаарлалт нь ТЗК-иудын гаргасан Ипотекийн зээлээр баталгаажсан бондтой (“ИЗББ”) холбогдох бөгөөд үүний дүнд дээрх нөөц хөрөнгө СЗХ-ны холбогдох журам болон дүрэмд заасны дагуу ТЗК-иудыг татан буулгах хүртэл хуваарилахаас хязгаарласан.

МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ОХИН КОМПАНИУД
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

	2021	2020
	мян.төг	мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	187,262,411	297,084,034
Үйлчилгээ үзүүлсний орлого	186,326,414	296,198,110
Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	935,996	885,924
Мөнгөн зарлагын дүн	238,982,811	312,168,874
Ажилчдад төлсөн	4,340,314	5,229,291
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,150,656	519,168
Бараа материал худалдан авахад төлсөн	48,409	132,337
Ашиглалтын зардалд төлсөн	173,132	261,584
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,932	36,864
Хүүгийн төлбөрт төлсөн	180,030,529	267,646,224
Татварын байгууллагад төлсөн	17,239,013	16,097,191
Даатгалын төлбөрт төлсөн	14,147	28,677
Бусад мөнгөн зарлага	35,960,679	22,217,538
Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ	(51,720,401)	(15,084,840)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	939,032,449	512,702,306
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	92,347	91,950
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	793,688
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	932,632,745	509,068,202
Хүлээн авсан Хүүгийн орлого	6,307,356	2,748,466
Мөнгөн зарлагын дүн	14,376,872	22,175,931
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	353,719	3,215,141
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	138,877
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	7,000,000	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	14,000
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	7,023,153	18,807,913
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	924,655,577	490,526,375
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	750,008,730	16,000
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	750,008,730	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	16,000
Мөнгөн зарлагын дүн	1,297,551,770	479,365,871
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,297,551,770	479,365,871
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(547,543,040)	(479,349,871)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	325,392,138	(3,908,337)
1 дүгээр сарын 1-ний өдрөөрх мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	224,428,670	228,337,007
12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	549,820,809	224,428,670